ЛӨРӨВЛҮГЭЭР БҮЛЭГ

ХҮН АМЫН СУУРЬШИЛ, НЯГТРАЛ



ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Төв аймгийн хүн амын суурьшлын дүр төрх өнгөрсөн 11 жилийнхээс бага зэрэг өөрчлөгдлөө. Энэ нь төв суурин газар руу чиглэсэн шилжих хөдөлгөөн, ялангуяа аймгийн баруун, зүүн бүсээс нийслэлд олон мянган хүн шилжсэн нь хүн ам сийрэгжихэд нөлөөлжээ (хүснэгт 4.1).

Хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 25.4 хувь нь төвийн бүс, 29.8 хувь нь баруун бүс, 14.3 хувь нь зүүн бүс 30.5 хувь нь хойд бүсэд оршин сууж байна.

ХҮСНЭГТ 4.1. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ӨСӨЛТ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Бүс, нутаг	Хүний тоо		2010	%	Дүнд эзлэх хувь	
	2000	2010	2000		2000	2010
БҮГД	**99 268**	**83 838**	**84.5**		**100.0**	**100.0**
Төвийн бүс	25 771	21 302	82.7		26.0	25.4
Зүүн бүс	14 727	11 993	81.4		14.8	14.3
Баруун бүс	32 656	24 999	76.6		32.9	29.8
Хойд бүс	26 114	25 544	97.8		26.3	30.5

Ерөнхийдөө хүн амын шилжилт хөдөлгөөн аймгаас Улаанбаатар руу чиглэж байгаа нь олон баримтаас харагдана. Учир нь дийлэнх сумын хүн амын тоо буурч, аймгийн дүнд эзлэх хувийн жин нь багасахад Улаанбаатарынх эрчимтэй өсч байгааг дараах хүснэгтээс харж болно.

[1] "Сумдыг эдийн засгаар бүсчлэхийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Долоодугаар хуралдааны 1998 оны 12 дугаар сарын II-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлав." Баруун бүсэд Баянхагай, Бүрэн, Дэлгэрхаан, Заамар, Лүн, Өндөрширээт, Угтаал, Цээл, Эрдэнэсант сум; Хойд бүсэд Аргалант, Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр сум; Төвийн бүсэд Алтанбулаг, Баян-Өнжүүл,Баянцагаан, Сэргэлэн, Зуунмод сум; Зүүн бүсэд: Архуст, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт, Эрдэнэ сум багтана.

ХҮСНЭГТ 4.2. ХҮН АМЫН ТОО, СУМААР, ӨСӨЛТ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Сумын нэр	Хүний тоо		2010	%	Дүнд эзлэх хувь	
	2000	2010	2000		2000	2010
БҮГД	**99 268**	**83838**	**84.5**		**100.0**	**100.0**
Алтанбулаг	3 702	2 420	65.4		3.7	2.9
Аргалант	1 988	1 371	69.0		2.0	1.6
Архуст	2 008	1 214	60.5		2.0	1.4
Батсүмбэр	6 537	6 913	105.8		6.6	8.2
Баян	3 193	1 963	61.5		3.2	2.3
Баяндэлгэр	2 058	1 477	71.8		2.1	1.8
Баянжаргалан	1 789	1 378	77.0		1.8	1.6
Баян-Өнжүүл	2 503	1 511	60.4		2.5	1.8
Баянхангай	1 710	1 253	73.3		1.7	1.5
Баянцагаан	2 724	1 401	51.4		2.7	1.7
Баянцогт	2 430	1 739	71.6		2.4	2.1
Баянчандмань	3 458	3 740	108.2		3.5	4.5
Борнуур	4 206	4 368	103.9		4.2	5.2
Бүрэн	3 473	2 777	80.0		3.5	3.3
Дэлгэрхаан	2 470	1 371	55.5		2.5	1.6
Жаргалант	5 513	5 657	102.6		5.6	6.7
Заамар	6 342	6 568	103.6		6.4	7.8
Лүн	3 697	2 418	65.4		3.7	2.9
Мөнгөнморьт	2 569	2 152	83.8		2.6	2.6
Өндөрширээт	2 265	1 686	74.4		2.3	2.0
Сүмбэр	1 982	1 756	88.6		2.0	2.1
Сэргэлэн	2 005	2 631	131.2		2.0	3.1
Угтаал	3 534	2 314	65.5		3.6	2.8
Цээл	3 671	2 561	69.8		3.7	3.1
Эрдэнэ	3 110	3 809	122.5		3.1	4.5
Эрдэнэсант	5 494	4 051	73.7		5.5	4.8
Зуунмод	14 837	13 339	89.9		14.9	15.9

Хөдөө аж ахуйд 2000 оноос хойш тохиолдсон ган, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдэл малчдад хүндээр тусч, нийслэл болон бусад томоохон хот, суурин газар руу шилжих хөдөлгөөн нэмэгджээ. Хот, суурингууд эрүүл мэнд, боловсрол болон ахуйн үйлчилгээ, хамгийн гол нь ажлын байр олох найдвартай газар болж, хүмүүс ихээр татагдаж байгаа нь хотжих үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна.

Дээрх шалтгааны улмаас аймгийн хүн ам буурч, 2000 онд улсын нийт хүн амын 4.2 хувь буюу 99268 хүн аймагт амьдарч байсан бол 2010 онд нийт хүн амын 3.2 хувь буюу 83838 хүн амьдардаг болж 15.5 мянган хүнээр буурлаа.

ХҮСНЭГТ 4.3. ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Бүс, нутаг	Хот			Хөдөө	
	Сумын тоо	Хүн ам	Бүсийн хүн амд эзлэх хувь	Хүн ам	Бүсийн хүн амд эзлэх хувь
2000 он	27	16227	16.3	83041	83.7
2010 он	27	13339	15.9	70499	84.1
Төвийн бүс	5	13339	15.9	7963	9.5
Зүүн бүс	6	-	-	11993	14.3
Баруун бүс	9	-	-	24999	29.8
Хойд бүс	7	-	-	25544	30.5

Сумын хүн амын эзлэх хувь төмөр зам, хатуу хучилттай автозам зам, хөдөө аж ахуй, уул уурхайн дагуу байрладаг Батсүмбэр, Заамар, Жаргалант, Эрдэнэсант, Борнуур сумдад өндөр байна.

ЗУРАГ 4.1 ХҮН АМЫН СУУРЬШЛЫН БАЙДАЛ,2010 ОН



ХҮН АМЫН НЯГТРАЛ

Бүс нутаг, аймаг, нийслэлийн хүн амын нягтралд хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйлсийн нэгд шилжих хөдөлгөөн орно.

Төв аймгийн нэг километр квадрат нутаг дэвсгэрт 2000 онд 1.3 хүн ногдож байсан бол 2010 онд буурч 1.1 болов. Төв аймаг дундаж суурьшилтай аймгийн нэг хэвээр байна.

Зуунмод хот хүн амын нягтралаараа хамгийн өндөр. Энэ сумын нэг километр квадрат нутаг дэвсгэрт 2000 онд 774 хүн ногдож байснаа 2010 онд 696 болж, 10.0 хувиар буурлаа.

Зуунмод хот аймгийн бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг атлаа хүн амын 15.3 хувь нь энд оршин суудаг, энэ байдал цаашид ч нэмэгдэх хандлагатай юм. Сумдын хүн амын нягтрал хоорондоо нэлээд ялгаатай. Ерөнхийдөө хойд болон баруун хойд бүсийн сумд хот маягийн суурин олон байдагтай холбоотойгоор өмнөд болон зүүн бүсийн сумдыг бодвол харьцангуй нягтрал ихтэй гарлаа.

ЗУРАГ 4.2. ХҮН АМЫН НЯГТРАЛ, СУМААР, 2010 ОН



Зуунмод хотоос гадна Баянчандмань (нэг километр квадратад 6.1 хүн), Сүмбэр сум (нэг километр квадратад 5 хүн) хүн амын нягтрал бусад сумаас хамгийн өндөр юм.

ХҮСНЭГТ 4.4 ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, СУМ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Сумын нэр	2000			2010		
	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км^2	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн/км^2
БҮГД	**99 268**	**100.0**	**1.3**	**83 838**	**100.0**	**1.1**
Алтанбулаг	3 702	3.7	0.7	2 420	2.9	0.4
Аргалант	1 988	2.0	1.8	1 371	1.6	1.2
Архуст	2 008	2.0	2.4	1 214	1.4	1.5
Батсүмбэр	6 537	6.6	2.7	6 913	8.2	2.8
Баян	3 193	3.2	1.1	1 963	2.3	0.7
Баяндэлгэр	2 058	2.1	1.0	1 477	1.8	0.7
Баянжаргалан	1 789	1.8	0.8	1 378	1.6	0.6
Баян-Өнжүүл	2 503	2.5	0.5	1 511	1.8	0.3
Баянхангай	1 710	1.7	1.7	1 253	1.5	1.2
Баянцагаан	2 724	2.7	0.4	1 401	1.7	0.2
Баянцогт	2 430	2.4	1.7	1 739	2.1	1.2
Баянчандмань	3 458	3.5	5.6	3 740	4.5	6.1
Борнуур	4 206	4.2	3.7	4 368	5.2	3.8
Бүрэн	3 473	3.5	0.9	2 777	3.3	0.7
Дэлгэрхаан	2 470	2.5	1.1	1 371	1.6	0.6
Жаргалант	5 513	5.6	3.0	5 657	6.7	3.0
Заамар	6 342	6.4	2.3	6 568	7.8	2.3
Лүн	3 697	3.7	1.5	2 418	2.9	1.0
Мөнгөнморьт	2 569	2.6	0.4	2 152	2.6	0.3
Өндөрширээт	2 265	2.3	0.8	1 686	2.0	0.6
Сүмбэр	1 982	2.0	5.7	1 756	2.1	5.0
Сэргэлэн	2 005	2.0	0.5	2 631	3.1	0.7
Угтаал	3 534	3.6	2.3	2 314	2.8	1.5
Цээл	3 671	3.7	2.2	2 561	3.1	1.5
Эрдэнэ	3 110	3.1	0.4	3 809	4.5	0.5
Эрдэнэсант	5 494	5.5	1.8	4 051	4.8	1.3
Зуунмод	14 837	14.9	773.6	13 339	15.9	695.5

Сумдын хүн амын нягтрал шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор ерөнхийдөө буурах хандлагатай ажээ. Дээр дурдсан 2 сум, Зуунмод хотын дараагаар тэдгээртэй харьцуулахад бага нягтралтай (нэг км квадрат нутаг дэвсгэрт 3.0-3.8 хүн ногдож байгаа) Жаргалант, Борнуур сумууд орлоо. Харин Мөнгөнморьт, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцагаан, сум хүн амын нягтрал хамгийн сийрэг, нэг километр квадрат нутаг дэвсгэрт 0.2-0.4 хүн ногдлоо.

ДҮГНЭЛТ

Төв аймгийн хүн амын нягтрал 2000 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 1.3 хүн ногдож байсан бол 2010 онд 1.1 болж буурахад хүн амын шилжих хөдөлгөөн ихээхэн нөлөөлсөн юм. Төв аймаг дундаж суурьшилтай аймгийн нэг хэвээр байна.

Манай аймагт Зуунмод, Баянчандмань, Сүмбэр сумын хүн амын нягтрал бусад сумаас хамгийн өндөр юм. Зуунмод сумын нэг километр квадрат нутаг дэвсгэрт 2000 онд 774 хүн ногдож байснаа 2010 онд 696 болж, 10.0 хувиар буурлаа. Зуунмод хот аймгийн бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг атлаа хүн амын 15.3 хувь нь энд оршин суудаг, энэ байдал цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

ТАВЛУГААР БҮЛЭГ

ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөн сүүлчийн 20 орчим жилд маш их идэвхжсэн. Тооллогоор байнга оршин сууж байсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс (аймаг, нийслэлийн төвшинд) өөр газар руу 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар шилжин суурьшсан хүн амыг шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үзсэн. Тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс, гол төлөв хөдөөнөөс мэргэжил, боловсрол эзэмших, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээнд ойртох, хөдөлмөр эрхлэх зэрэг шалтгаанаар төв суурин газар руу шилжих нь нэмэгдэв.

Шилжих хөдөлгөөнийг тодорхой цаг хугацаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үздэг. Тооллогоор шилжих хөдөлгөөнийг тооллогын товын үед:

- төрсөн нутгаасаа өөр газар амьдарч байгаа;
- таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газраасаа өөр газарт шилжиж ирсэн (Үүнд 5 жил 11 сарын хөдөлгөөнийг хамруулав.);
- нэг жилийн өмнө байнга оршин сууж байсан газраасаа өөр газарт шилжиж ирсэн (Үүнд 11 сарын хөдөлгөөнийг хамруулав.) гэсэн гурван үндсэн хугацаагаар авсан.

Шилжих хөдөлгөөнийг тухайн хүн дээрх хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан хамгийн сүүлд шилжсэн нутаг дэвсгэрийн байдлаар, нутаг дэвсгэрийг байнга оршин сууж байсан аймгаас нийслэлд эсвэл өөр аймагт, нийслэлээс аймагт шилжсэн байдлаар тодорхойлов.

ЗУРАГ 5.1. ТӨРСНӨӨСӨӨ ХОЙШИХ ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2010 ОН

Төрсөн аймаг, нийслэлдээ тооллогын товын үед байнга оршин сууж байсан хүн амыг "Төрснөөсөө хойш сууж байгаа" буюу амьдралынхаа туршид оршин суугаа газраа өөрчлөөгүй гэж үзсэн. Харин тооллогын товын үед төрсөн аймаг, нийслэлээсээ өөр газар байнга оршин сууж байгаа, тооллогын товын үед төрсөн газраа байнга оршин сууж байгаа боловч амьдралынхаа аль нэг хугацаанд бусад газарт 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар сууж байгаад эргэж ирсэн хүмүүсийг "Төрснөөсөө хойш шилжигчид" гэж үзэв.

Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа 83838 хүн амын 56.6 хувь буюу 47 468 хүн тус аймагт төрснөөсөө хойш амьдарч, 43.4 хувь буюу 36 70 хүн шилжиж ирсэн бол үүний 98.9 хувь буюу 35956 хүн өөр аймаг, нийслэлээс, 1.1 хувь буюу 414 хүн гадаадаас шилжиж иржээ. Өмнөх 2000 оны тооллогоос тус аймагт төрснөөсөө хойш амьдарч байгаа хүн 13695 буюу 22.4 хувиар, шилжиж ирсэн хүн 1735 буюу 4.5 хувиар тус бүр буурлаа.

ХҮСНЭГТ 5.1. ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО, ТӨРСӨН БҮС НУТГААР, 2010 ОН

Шилжин ирсэн, явсан бүс нутаг	Хүн амын тоо	Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний байдал					Цэвэр шилжих хөдөлгөөн
		Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжин ирэгчид	Дүнд эзлэх хувь	Шилжин явагчид	Дүнд эзлэх хувь	
БҮГД	**83 838**	**47 468**	**36 370**	**100.0**	**73 014**	**100.0**	**- 36 644**
Баруун бүс	7 064	-	7 064	19.5	1 402	1.9	5 662
Хангайн бүс	5 963	-	5 963	16.4	3 777	5.2	2 186
Төвийн бүс	53 399	47 468	5 931	16.3	6 040	8.3	- 109
Зүүн бүс	1 680	-	1 680	4.6	1 012	1.4	668
Улаанбаатар	15 318	-	15 318	42.1	60 783	83.2	- 45 465
Гадаадаас	414	-	414	1.1	-	-	-

Шилжин ирсэн нийт хүн амын 53.6 хувь буюу 19485 нь эрэгтэйчүүд, 46.4 хувь буюу 16885 нь эмэгтэйчүүд юм. Шилжин ирсэн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 760 хүнээр их байна. Харин төрснөөсөө хойш амьдарч байгаа нийт хүн амын 54.1 хувь нь эрэгтэйчүүд 48.9 хувийг эмэгтэйчүүд эзлэв. Эндээс үзэхэд шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүдийн идэвх илүү их байгаа нь харагдлаа.

Төв аймагт шилжин ирсэн хүн амын 18.3 хувь нь Улаанбаатар хотоос, 9.2 хувь нь Завхан, Дундговь, Өвөрхангай, Увс, Говь-Алтай аймгаас шилжин ирж суурьшжээ.

ХҮСНЭГТ 5.2 ТӨВ АЙМАГТ ОРШИН СУУГАА ХҮН АМ, ШИЛЖИН ИРСЭН АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Шилжих ирэхийн өмнө оршин сууж байсан аймаг, нийслэл	Аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	**83 838**	**43 751**	**40 087**	**100.0**	**100.0**	**100.0**
Төв	47 468	24 266	23 202	56.6	55.5	57.9
Улаанбаатар	15 318	8 074	7 244	18.3	18.5	18.1
Завхан	2 389	1 206	1 183	2.8	2.9	3.0
Дундговь	1 927	909	1 018	2.3	2.1	2.5
Өвөрхангай	1 871	986	885	2.2	2.3	2.2
Увс	1 779	925	854	2.1	2.1	2.1
Говь-Алтай	1 684	820	864	2.0	1.9	2.2
Сэлэнгэ	1 473	791	682	1.8	1.8	1.7
Архангай	1 226	648	578	1.5	1.5	1.4
Дорноговь	1 223	920	303	1.5	2.1	0.8
Баянхонгор	860	455	405	1.0	1.0	1.0
Дархан-Уул	860	413	447	1.0	0.9	1.1
Ховд	780	433	347	0.9	1.0	0.9
Хөвсгөл	772	403	369	0.9	0.9	0.9
Булган	716	345	371	0.9	0.8	0.9
Бусад	3 492	2157	1335	4.2	4.9	3.3

Олон улсад шилжих хөдөлгөөний чиг хандлагыг цаг хугацаагаар хэмжин судалдаг жишгийг үндэслэн хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоос эхлэн таван жилийн өмнөх шилжих хөдөлгөөнийг судалсан. Үүнийг тоолуулагч 2005 оноос өмнө болон хойших хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан товын үед болон товоос таван жилийн өмнө байнга сууж байсан газраар тооцоолсон болно. 2000 оны тооллогын тов 1 дүгээр сарын 4-өөс 5-нд шилжих шөнө байсан бол 2010 оных 11 дүгээр сарын 10-аас 11-нд шилжих шөнө байсан гэдгийг судлаачид харгалзаж үзэх нь зүйтэй. Та 2005 оны 1 дүгээр сард хаана байнга амьдарч байсан бэ гэсэн асуултаар 5 ба түүнээс дээш настай хүн амын сүүлийн 5 жилийн дотоод шилжих хөдөлгөөнийг харуулахыг зорьсон.

ЗУРАГ 5.2. СҮҮЛЧИЙН ТАВАН ЖИЛИЙН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2010 ОН

Тав, түүнээс дээш насны хүн амын 60319 буюу 82.4 хувь сүүлчийн 5 жилийн шилжих хөдөлгөөнд ороогүй, 17.6 хувь буюу 12908 хүн шилжин иржээ. Харин шилжиж явсан 16031 хүн байгаа нь аймгийн хүн амын 21.9 хувьтай тэнцүү байна. Энэ нь Улаанбаатар хоттой ойрхон учир хот суурин газарт сурч, ажиллаж амьдрах, хүмүүсийн тоо жилээс жилд нэмэгдсэнийг харууллаа.

ХҮСНЭГТ 5.3. ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН СҮҮЛЧИЙН 5 ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Хүйс	Нийт хүн ам	Шилжих хөдөлгөөнд ороогүй	Шилжиж ирсэн	Шилжиж явсан	Цэвэр шилжилт
БҮГД	**73 227**	**60 319**	**12 908**	**16 031**	**-3123**
Эрэгтэй	38 260	31 298	6 962	8 097	-1135
Эмэгтэй	34 967	29 021	5 946	7 934	-1988

Төв аймгийн тав, түүнээс дээш насны хүн амын сүүлчийн таван жилд шилжин ирэгчдийн аймгийн хүн амд эзлэх хувь 17.6 хувь байна.

ХҮСНЭГТ 5.4 АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО, ШИЛЖИЖ ИРЭЭД СУУЖ БАЙГАА ХУГАЦААГААР, 2010 ОН

Шилжиж ирээд сууж байгаа хугацаагаар	Хүн ам	Шилжиж ирсэн хүний тоо		Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	**36370**	**19485**	**16885**	**115.4**
1 жил хүртэл	4524	2442	2082	117.3
1-3 жил	7932	4081	3851	106.0
4 жил	1648	826	822	100.5
5-6 жил	3013	1815	1198	151.5
7-9 жил	2832	1472	1360	108.2
10-12 жил	2919	1553	1366	113.7
13-15 жил	1855	977	878	111.3
16-19 жил	1664	888	776	114.4
20, түүнээс дээш жил	9983	5431	4552	119.3

Энд нийт шилжин ирсэн хүн амын 27.4 хувь буюу 9983 хүн 20 ба түүнээс дээш жил, 21.8 хувь буюу 7932 хүн 1-3 жил оршин сууж байгаа нь харагдлаа. Шилжин ирсэн эрэгтэйчүүдийн 27.9, эмэгтэйчүүдийн 27.0 хувь нь 20-иос дээш жилийн өмнө шилжин ирж суурьшсан ба сүүлчийн жилүүдэд шилжин ирэгчид багасах, харин шилжин явагчид нэмэгдэх хандлагатай байна.

Нийт шилжин ирэгчдийн 4524 буюу 12.4 хувь нь сүүлчийн 1 жилийн дотор, 13931 буюу 38.3 хувь нь 4-19 жилийн өмнө Төв аймагт шилжиж иржээ. Шилжин ирэгчдийн хүйсийн харьцаанаас харахад шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд илүү оролцожээ.

Төв аймгаас Улаанбаатар хот, бусад аймагт шилжигсдийн тоо жил ирэх тусам өссөөр байна. Төв аймгийн хувьд хүн амын шилжих хөдөлгөөний хамгийн их сөрөг урсгалтай (шилжин явагчдын тоо шилжин ирэгчдийн тооны зөрүү)-д Улаанбаатар, түүний дараа Өмнөговь аймаг оржээ. Харин шилжих хөдөлгөөний хамгийн их эерэг урсгалтай нь зэргэлдээ аймаг болох Өвөрхангай, Дундговь байна.

ХҮСНЭГТ 5.5. ТӨВ АЙМГИЙН ХҮН АМЫН СҮҮЛЧИЙН НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

Аймаг, нийслэл	Шилжин ирэгчид		Шилжин явагчид		Цэвэр шилжилт	
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь
Сөрөг урсгалын дүн	**2 302**	**100.0**	**4 507**	**100.0**	**-2205**	**100.0**
Дорноговь	51	2.2	66	1.5	-15	0.7
Өмнөговь	20	0.9	124	2.7	-104	4.7
Сэлэнгэ	126	5.4	172	3.8	-46	2.1
Дархан-Уул	96	4.2	147	3.3	-51	2.3
Улаанбаатар	1 987	86.3	3 970	88.1	-1983	89.9
Говьсүмбэр	22	1.0	28	0.6	-6	0.3
Эерэг урсгалын дүн	**2 210**	**100.0**	**323**	**100.0**	**1887**	**100.0**
Архангай	144	6.5	6	1.9	138	7.3
Баян-Өлгий	10	0.4	4	1.2	6	0.3
Баянхонгор	101	4.6	22	6.8	79	4.2
Булган	73	3.3	43	13.4	30	1.6
Говь-Алтай	152	6.9	19	5.9	133	7.0
Дорнод	41	1.9	31	9.6	10	0.5
Дундговь	406	18.4	35	10.8	371	19.7
Завхан	277	12.5	6	1.9	271	14.4
Өвөрхангай	327	14.8	25	7.7	302	16.0
Сүхбаатар аймаг	26	1.2	0	0.0	26	1.4
Төв	0.0	0.0	0	0.0	0.0	0.0
Увс	250	11.3	15	4.6	235	12.4
Ховд	88	4.0	4	1.2	84	4.4
Хөвсгөл	54	2.4	20	6.2	34	1.8
Хэнтий	71	3.2	47	14.6	24	1.3
Орхон аймаг	70	3.2	46	14.2	24	1.3
Гадаадад	120	5.4	0	0.0	120	6.4

ХОТЖИЛТ

Хүн ам харьцангуй олон Төв аймагт хотын хүн амын эзлэх хувийн жин харьцангуй бага, хөдөөгийн хүн амын эзлэх хувийн жин өндөр (83.1 хувь) эзэлдэг онцлог хандлага харагдлаа. Төв аймаг өөрийн гэсэн онцлогтой. Нийслэл хот өргөжиж байгаа ч Төв аймгийн хөдөөгийн хүн амын эзлэх хувь бараг хэвээрээ хадгалагдсан. Гэхдээ Төв аймгийн иргэд аймгийн төв рүүгээ шилжихийг гол болгохгүй нийслэлд шууд шилжиж байгаа онцлог ч бас бий юм.

Аймгийн нийт хүн амын 15.9 хувь нь Зуунмод хотод төвд амьдарч байна. 2000 оноос хотын хүн ам 2888 хүнээр буюу 17.8 хувиар буурлаа.

ХҮСНЭГТ 5.6. МОНГОЛ УЛСЫН ХОТЫН ХҮН АМЫН ТОО, БҮС НУТАГ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Хотын хүн амын тоо		2010/2000 (%)	Дүнд эзлэх хувь	
	2000	2010		2000	2010
БҮГД	1 344 516	1 798 147	132. 7	100.0	100.0
Баруун бүс					
Дүн	**122 701**	**122 334**	**97.1**	**9.1**	**6.8**
Баян-Өлгий	28 060	30 663	107.4	2.1	1.7
Говь-Алтай	18 023	17 962	94.6	1.3	1.0
Завхан	24 276	17 485	72.1	1.8	1.0
Увс	26 319	27 178	96.3	2.0	1.5
Ховд	26 023	29 046	111.6	1.9	1.6
Хангайн бүс					
Дүн	**175 681**	**225 221**	**126.1**	**13.1**	**12.5**
Архангай	18 519	20 619	107.8	1.4	1.1
Баянхонгор	22 066	29 829	135.0	1.6	1.7
Булган	16 239	14 116	84.6	1.2	0.8
Орхон	68 310	84 187	120.8	5.1	4.7
Өвөрхангай	19 058	38 027	199.2	1.4	2.1
Хөвсгөл	31 489	38 443	119.2	2.3	2.1
Төвийн бүс					
Дүн	**201 357**	**211 451**	**102.7**	**15.0**	**11.8**
Говьсүмбэр	8 983	9 742	96.8	0.7	0.5
Дархан-Уул	65 791	74 985	112.9	4.9	4.2
Дорноговь	25 210	33 932	132.9	1.9	1.9
Дундговь	14 517	13 664	81.2	1.1	0.8
Өмнөговь	14 183	18 781	129.0	1.1	1.0
Сэлэнгэ	56 446	47 008	82.9	4.2	2.6
Төв	16 227	13 339	83.1	1.2	0.7
Зүүн бүс					
Дүн	**84 700**	**84 851**	**97.8**	**6.3**	**4.7**
Дорнод	41 714	38 615	92.9	3.1	2.1
Сүхбаатар	15 133	16 150	94.0	1.1	0.9
Хэнтий	27 853	30 086	107.4	2.1	1.7
Улаанбаатар	**760 077**	**1154290**	**151.9**	**56.5**	**64.2**

ДҮГНЭЛТ

Нийт шилжин ирсэн хүн амын 27.4 хувь буюу 9983 хүн 20 ба түүнээс дээш жил, 21.8 хувь буюу 7932 хүн 1-3 жил оршин сууж байгаа нь харагдлаа. Шилжин ирсэн эрэгтэйчүүдийн 27.9, эмэгтэйчүүдийн 2.76 хувь нь 20, түүнээс дээш жилийн өмнө шилжин ирж суурьшсан ба сүүлчийн жилүүдэд шилжин ирэгчид багасах хандлагатай болж, шилжин явагчид өсөх хандлагатай байна.

Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа 83838 хүн амын 56.6 хувь буюу 47 468 хүн тус аймагт төрснөөсөө хойш амьдарч, 43.4 хувь буюу 36 70 хүн шилжиж ирсэн бол үүний 98.9 хувь буюу 35956 хүн өөр аймаг, нийслэлээс, 1.1 хувь буюу 414 хүн гадаадаас шилжиж иржээ. Шилжин ирсэн нийт хүн амын 53.6 хувь буюу 19485 нь эрэгтэйчүүд, 46.4 хувь буюу 16885 нь эмэгтэйчүүд юм. Эндээс үзэхэд шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүдийн идэвх илүү их байгаа нь харагдлаа.

Тав, түүнээс дээш насны хүн амын 60319 буюу 82.4 хувь сүүлчийн 5 жилийн шилжих хөдөлгөөнд ороогүй, 17.6 хувь буюу 12908 хүн шилжин иржээ. Харин шилжиж явсан 16031 хүн байгаа нь аймгийн хүн амын 21.9 хувьтай тэнцүү байна. Энэ нь Улаанбаатар хоттой ойрхон учир хот суурин газарт сурч, ажиллаж амьдрах, хүмүүсийн тоо жилээс жилд нэмэгдсэнийг харууллаа.

Нийт шилжин ирэгчдийн 4524 нь буюу 12.4 хувь нь сүүлчийн 1 жилийн дотор, 13931 буюу 38.3 хувь нь 4-19 жилийн өмнө тухайн аймагт шилжиж иржээ. Шилжин ирэгчдийн хүйсийн харьцаанаас харахад шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд илүү оролцожээ.

Төв аймгийн хөдөөгийн хүн амын эзлэх хувь бараг хэвээрээ хадгалагдсан. Гэхдээ Төв аймгийн иргэд аймгийн төв рүүгээ шилжихийг гол болгохгүй нийслэлд шууд шилжиж байгаа онцлог ч бас бий юм.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Боловсрол нь хүн амын ажиллаж, амьдрах чадавх, хүмүүн капиталд оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг харуулах чухал үзүүлэлт юм. Тооллогоор хүн амын боловсролын түвшинг тодорхойлох нь хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд, ажиллах хүч, шилжих хөдөлгөөн, байршил, орон сууц зэрэг үндэсний болон бүс нутаг, аймаг, нийслэлийн хэмжээний бодлого, төлөвлөлтийг боловсруулахад нэн чухал билээ.

Боловсролын тухай Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлд "Боловсролын агуулга нь суралцагчийн нас, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ"[1] гэж заасан үндсэн агуулгад сүүлчийн тооллогуудын асуулга, аргачлал, заавар, үр дүн нийцэж байгаа.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын асуулгад бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшинд холбогдох асуултыг 6, түүнээс дээш насны бүх хүнээс, 2-39 насны хүнээс сургуульд сурдаг, цэцэрлэгт хүмүүждэг эсэхийг асуусан.

Бага, дунд боловсролын тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлд "Бага боловсролыг 6, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлнэ"[2], мөн Дээд боловсролын тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлд "Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх сургалтын кредит цагийг оролцуулан тооцон бакалаврын сургалт 120 багц цагаас, магистрын сургалт 150 багц цагаас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна"[3] гэж заажээ.

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойших 20 орчим жилд боловсролын тогтолцоог шинэчилж, хөгжингүй орны боловсролын стандартыг нэвтрүүлж байна. Тиймээс тооллого хоорондын хүн амын боловсролын түвшинг зэрэгцүүлэн жишиж өөрчлөлтийг харах нь чухал билээ. Төвлөрсөн төлөвлөлгөөт нийгмийн харилцаанд мөрдөж байсан боловсролын ангилал 2000 оны тооллогын үеийнхээс нэлээд ялгаатай болсон тул 1989, 2000 оны тооллогын дүнг тодорхой хэмжээгээр бүлэглэж зэрэгцүүлсэн. Энэ удаа хүн амын боловсролын түвшинг НҮБ-ын зөвлөмж, олон улсын нийтлэг жишгийг харгалзан 10, түүнээс дээш насныханд тодорхойлов.

Арав, түүнээс дээш настай хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхээс 4.8 пунктээр нэмэгдэж, 91.4 хувь боллоо.

---

[1] Боловсролын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл III боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 369

[2] Бага, дунд боловсролын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл III боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 392

[3] Дээд боловсролын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл III боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 404

ХҮСНЭГТ 6.1. АРАВ ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН

Боловсролын түвшин	2000			2010		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**
Боловсролгүй	13.4	13.4	13.4	8.6	9.5	7.7
Боловсролтой	86.6	86.6	86.6	91.4	90.5	92.3
Дээд	4.0	4.0	3.9	10.1	7.8	12.6
Тусгай мэргэжлийн дунд	6.4	4.3	8.6	5.5	4.0	7.2
Техникийн болон мэргэжлийн	5.3	5.7	4.8	4.4	4.8	3.8
Бүрэн дунд	14.9	12.7	17.4	25.8	24.1	27.6
Суурь	29.8	33.0	26.4	26.2	29.0	23.2
Бага	26.2	26.9	25.5	19.4	20.8	17.9

Улсын болон хувийн хэвшлийн олон их, дээд сургууль байгуулагдаж, түүнд олон арван мянган залуучууд суралцан, төгсөж байгаагийн дүнд 10, түүнээс дээш насны нийт хүн амд дээд боловсролтой хүний эзлэх хувь өнгөрсөн 11 жилд 6.1 пунктээр нэмэгдсэн нь нэг талаар сайн үзүүлэлт боловч нөгөө талдаа үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллах мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн хувь буурлаа. Мөн бага болон суурь боловсрол эзэмшигчдийн хувийн жин буурч, бүрэн дунд боловсрол эзэмшигчдийнх өссөн нь нэг талаас эцэг эхчүүд хүүхэддээ аль болох дээд боловсрол эзэмшүүлэх сонирхолтой болсонтой холбоотой.

Боловсрол эзэмшигчдийг хүйсээр ангилж үзэхэд нэлээд ялгаатай байдал ажиглагдлаа. Ялангуяа, дээд боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь тооллого хооронд 3.8 пунктээр өссөн байхад эмэгтэйчүүдийнх 8.7 пунктээр нэмэгджээ. Гэтэл тусгай мэргэжлийн дунд, мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн хувь буурсны дотор эмэгтэйчүүдийнх нь эрэгтэйчүүдийнхээс илүү буурлаа.

Арав, түүнээс дээш насны нийт хүн амд боловсролгүй хүн амын эзлэх хувь нэлэнхүйдээ буурсны дотор эмэгтэйчүүдийнх илүү буурчээ. Нийгмийн хөгжлийн явцад хүн амын боловсрол эзэмших хэрэгцээ, шаардлага, боломж, хандлага өөр өөр байлаа. Өмнөх тооллогуудын дүнгээс үзэхэд нас ахисан хүмүүсийн боловсролын түвшин залуу үеийнхтэй харьцуулахад бага байдаг байсан. Сүүлчийн үед нас дэвшилтээс шалтгаалан боловсрол өндөртэй залуу үе бага боловсролтой ахмад насны хүмүүсийг түрж, боловсролын төвшний ерөнхий байдал сайжрахад нөлөөлсөн.

Хүн амын боловсролын байдлыг хот, хөдөөгөөр ангилж үзэхэд ялгаатай тал харагдаж байна.

ХҮСНЭГТ 6.2. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Боловсролын төвшин	Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	5.6	6.3	4.9	9.2	10.0	8.3
Боловсролтой	94.4	93.7	95.1	90.8	90.0	91.7
Дээд	20.8	17.4	24.1	8.0	6.1	10.1
Тусгай мэргэжлийн дунд	7.4	5.4	9.2	5.2	3.8	6.8
Техникийн болон мэргэжлийн	3.0	3.3	2.7	4.6	5.1	4.0
Бүрэн дунд	34.3	35.7	33.1	24.1	22.0	26.5
Суурь	16.8	19.7	14.0	28.1	30.6	25.2
Бага	12.1	12.2	12.0	20.8	22.4	19.1

Хот, хөдөөгийн хүн амын боловсролын түвшин дээшлэх тутам тэр ялгаа нь нэмэгдэх ажээ. Боловсролгүй хүний эзлэх хувь хөдөөд хотоос 3.6 пунктээр их бол хотод дээд боловсролтой хүн амын эзлэх хувь хөдөөгийнхөөс 12.8 пунктээр их байна. Харин хотод бүрэн дунд боловсролтой хүн ам олон байхад хөдөөд суурь болон бага боловсролтой хүн илүү олон байна. Хөдөөгийн дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр, суурь болон бага боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс илүү байгаагаас үзэхэд хөдөөгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсролтой болжээ. Хотод энэ байдал бас давтагдаж байна.

ХҮСНЭГТ 6.3. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО,НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР 2010 ОН

Насны бүлэг	Бүгд	Дээд	Тусгай мэргэжлийн дунд	Техник болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
БҮГД	**100.0**	**10.1**	**5.5**	**4.4**	**25.8**	**26.2**	**19.4**	**8.6**
10-14	100.0	-	-	-	-	6.7	61.5	31.8
15-19	100.0	0.1	0.9	2.3	24.9	52.2	15.6	4.0
20-24	100.0	17.3	2.7	4.8	42.6	18.6	8.2	5.8
25-29	100.0	21.1	1.3	2.8	29.2	24.0	13.8	7.8
30-34	100.0	13.3	2.2	2.3	31.7	33.1	12.3	5.1
35-39	100.0	9.5	6.0	6.2	39.5	30.8	4.9	3.1
40-44	100.0	8.8	10.9	8.8	34.8	27.5	5.9	3.3
45-49	100.0	9.7	12.1	8.7	27.9	26.8	10.2	4.6
50-54	100.0	10.3	12.6	7.2	20.3	29.4	16.1	4.1
55-59	100.0	10.7	13.6	5.8	17.4	26.3	21.2	5.0
60+	100.0	10.8	9.7	3.0	10.9	15.7	37.2	12.7

Дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүний эзлэх хувь 25-29 наснаас буурч байснаа 50-54 насанд нэмэгдэж, цаашдаа өсчээ. Энэ нь 1960-аад оны эхнээс манай улсад дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой боловсон хүчнийг олноор нь бэлтгэж байсантай холбоотой. 60, түүнээс дээш насны хүмүүсийн боловсролын түвшин ерөнхийдөө доогуур, тэдний 1/3 нь бага боловсролтой, 12.7 хувь нь боловсролгүй байна. Харин 25-29 насны

дээд боловсролтой хүний эзлэх хувийн жин хамгийн өндөр байгаа нь зүй ёсных боловч энэ насны боловсролгүй хүний эзлэх хувь бусад наснаас өндөр байна. Энэ нь нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдсөн шилжилтийн үед сургууль завсардалт өндөр байсныг гэрчилнэ. Ерөнхийдөө 20-40 хүртэл насны хүмүүсийн боловсролын түвшин өндөр байна. Гэвч тухайн насны хүн амын дотор мэргэжлийн боловсролтой хүний эзлэх хувь бага байгаа нь үйлдвэрлэл, үйчилгээнд ажиллах мэргэжилтэй ажилчдын хүрэлцээ хангалтгүй байгааг харуулна.

Одоогоос 30 жил, түүнээс өмнө дээд боловсрол эзэмшсэн хүмүүсийн хувьд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс илүү байжээ. Харин 50 хүртэл насанд дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс илүү байгаагийн дотор 25-29 насанд хамгийн өндөр болов.

ЗУРАГ 6.1. ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Бичиг үсгийн мэдлэгийн тодорхойлолтын талаарх НҮБ-ын зөвлөмжийг 2000, 2010 оны тооллогод үндсэнд нь баримталсан юм. Аль нэг хэлээр энгийн өгүүлбэрийг уншиж ойлгодог, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзсэн. Зургаа, түүнээс дээш насны боловсролгүй хүнээс бичиг үсэг мэддэг эсэхийг тодруулж асуусан.

ЗУРАГ 6.2. ХҮН АМЫН ТОО, БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГЭЭР, 2010 ОН

Төв аймгийн 15 ба түүнээс дээш насны хүн амын 97.5 хувь бичиг үсэг мэдэж байгаа нь 2000 оноос 0.6 пунктээр өссөн боловч хот, хөдөөгийн оршин суугчдын хувьд ялгаа бий. Хотын бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь хөдөөгийнхөөс 1.2 пунктаар доогуур юм. Арван тав, түүнээс дээш насны хотын хүн амын 1.4 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаа нь хөдөөгийнхөөс 1.3 пунктээр доогуур юм. Арван тав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсэг мэдэж байгаа хүмүүсийн эзлэх хувь Төв аймгийнх улсын дунджаас 0.8 пунктээр доогуур гарлаа.

ХҮСНЭГТ 6.4 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХОТ ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Бичиг үсгийн мэдлэг	2000					2010				
	Бүгд	Байршил				Бүгд	Байршил			
		Хот		Хөдөө			Хот		Хөдөө	
	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь
БҮГД	**100.0**	**10568**	**100.0**	**52766**	**100.0**	**100.0**	**9863**	**100.0**	**49804**	**100.0**
Бичиг үсэг мэддэг	97.0	10344	97.9	51087	96.8	97.5	9722	98.6	48476	97.3
Бичиг үсэг мэддэггүй	3.0	223	2.1	1679	3.2	2.5	141	1.4	1328	2.7

2000 онтой харьцуулахад Төв аймагт отын бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь 0.7 пунктээр, хөдөөнгийнх 0.5 пунктээр буурчээ.

Бичиг үсэг мэдэхгүй хүн амын эзлэх хувийг насаар авч үзэхэд Төв аймгийн хувьд 15-29 насны залуучуудын 2.4 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаа нь бага мэт боловч хүнийхээ тооноос хамаарч тэд нийт бичиг үсэг мэддэггүй 15, түүнээс дээш насны хүн амын 36.1 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 6.3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД БИЧИГ ҮСЭГ МЭДДЭГГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010 ОН



СУРГУУЛЬ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор сургуульд суралцаж байгаа болон цэцэрлэгт хүмүүжиж байгаа эсэхийг 2-39 насныхнаас асуусан.

НҮБ-ын зөвлөмжийн дагуу сургуульд суралцах насыг 5-29 насаар авч үзэх ёстой боловч манай улсын боловсролын шинэ тогтолцооны дагуу хүүхдийг 6 наснаас эхлэн сургуульд элсүүлэх болсонтой холбогдуулан сургуульд хамрагдалтыг 6-29 насаар тодорхойлов.

Сургуульд хамрагдалт 11 жилийн өмнөхөөс сайжирчээ. Тухайлбал, 2000 онд 8 настай бүх хүүхдийн 87.6 хувь нь сургуульд сурч байсан бол 2010 онд 98.1 хувь болж өсчээ. Есөн настай хүүхдийн сургуульд хамрагдалт 2000 онд 94.0 байсан бол 2010 онд 98.6 хувь болж нэмэгдэв. Сургууль хамрагдалт 2010 онд 15 наснаас эхлэн буурч байгаагаас үзэхэд бүрэн дунд боловсрол эзэмших насны хүүхдийн сургуульд хамрагдалт эрс нэмэгдсэн гэж дүгнэх үндэслэлтэй юм (Хүснэгт 6.5).

ХҮСНЭГТ 6.5. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Нас	Сургуульд суралцаж байгаа			Сургуульд суралцаагүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
6-29	**55.9**	**52.1**	**60.4**	**44.1**	**47.9**	**39.6**
6	93.7	92.5	94.9	6.3	7.5	5.1
7	97.5	97.4	97.6	2.5	2.6	2.4
8	98.1	97.6	98.6	1.9	2.4	1.4
9	98.6	98.1	99.1	1.4	1.9	0.9
6-9	**97.0**	**96.5**	**97.6**	**3.0**	**3.5**	**2.4**
10	98.6	98.3	98.9	1.4	1.7	1.1
11	97.8	97.4	98.3	2.2	2.6	1.7
12	97.2	96.0	98.6	2.8	4.0	1.4
13	95.7	94.2	97.4	4.3	5.8	2.6
14	94.7	92.7	96.9	5.3	7.3	3.1
10-14	**96.8**	**95.7**	**98.0**	**3.2**	**4.3**	**2.0**
15	92.2	88.4	96.3	7.8	11.6	3.7
16	87.3	80.3	95.5	12.7	19.7	4.5
17	80.5	71.3	91.4	19.5	28.7	8.6
6-17	**94.4**	**92.0**	**97.1**	**5.6**	**8.0**	**2.9**
18	57.4	48.2	71.9	42.6	51.8	28.1
19	40.1	33.2	50.0	59.9	66.8	50.0
20-24	**15.9**	**12.5**	**20.3**	**84.1**	**87.5**	**79.7**
25-29	**3.8**	**2.9**	**4.8**	**96.2**	**97.1**	**95.2**

Хэдийгээр сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үеэс сайжирсан боловч анхаарах асуудлууд байсаар байна. Суурь боловсрол эзэмших насны хүүхдүүдийн дотор 12 наснаас сургуульд хамрагдалт мэдэгдэхүйц буурчээ. Ялангуяа, эрэгтэй хүүхдийн хувьд илүү байгаа юм. Бүх нийтээр суурь боловсрол эзэмших ёстой хэдий ч аймгийн хэмжээнд 2010 оны байдлаар 6-14 насны 415-н хүүхэд сургуульд суралцахгүй байгаагийн 274 буюу 66.0 хувь нь хөвгүүд, 141 буюу 33.9 хувь нь охид ажээ.

Сургуульд хамрагдалт хот, хөдөөд ялгаатай юм. Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт нийт дүнгээрээ хотод 62.7 хувь байхад хөдөөд түүнээс 8.1 пунктээр доогуур гарлаа. Энэ нь улсын дунджаас хотод 2.6 пунктээр , хөдөөд 0.8 пунктээр тус бүр илүү юм.

ХҮСНЭГТ 6.6. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Нас	Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
6-29	**62.7**	**60.3**	**65.2**	**54.6**	**50.5**	**59.4**
6	96.1	96.0	96.2	93.2	91.9	94.6
7	98.4	96.9	100.0	97.4	97.5	97.2
8	99.1	98.0	100.0	97.9	97.6	98.3
9	97.6	96.5	98.9	98.8	98.4	99.2
6-9	**97.8**	**96.8**	**98.8**	**96.9**	**96.4**	**97.4**
10-14	**98.9**	**98.6**	**99.2**	**96.5**	**95.2**	**97.8**
15-17	**95.9**	**93.1**	**98.8**	**85.2**	**78.1**	**93.7**
15	97.8	96.1	99.3	91.1	87.1	95.7
16	97.3	96.2	98.5	85.2	76.8	94.8
17	92.5	86.5	98.5	77.3	67.7	89.3
6-17	**97.7**	**96.5**	**99.0**	**93.8**	**91.2**	**96.7**
18	81.4	74.2	91.2	50.7	41.6	65.8
19	67.0	59.5	76.7	32.9	26.6	42.2
20-24	**32.7**	**28.1**	**38.0**	**12.2**	**9.3**	**16.1**
25-29	**7.7**	**6.9**	**8.4**	**3.0**	**2.2**	**4.0**

Суурь боловсрол эзэмших насны хүн амын сургуульд хамрагдалтын хувь хот, хөдөөгөөр харьцангуй ойролцоо байгаа боловч ахлах ангид дэвшин суралцах нас буюу 15 наснаас эхлэн зөрүү нь нэмэгдлээ. Арван найман наснаас эхлэн энэ хувь хотод 80-аас, хөдөөд 50-аас бага боллоо. Ялангуяа, мэргэжлийн сургуульд суралцах 20-24 насанд сургуульд хамрагдалт хотод хөдөөгөөс 20.7 пунктээр их байгаа юм. Дээд болон тусгай мэргэжлийн дунд сургууль хөдөөд байдаггүй, хөдөөгийн олон мянган охид хөвгүүд хот руу шилжиж сургуульд үргэлжлүүлэн суралцдаг тул хөдөөгийн залуучуудын сургуульд хамрагдалт ийнхүү бага гарчээ. Нөгөө талаар, тооллого 11 дүгээр сард явагдаж дээд, тусгай дунд, мэргэжлийн сургуульд суралцагчдыг сурч байгаа газарт нь байнга суугчаар тоолсон нь дээрх үзүүлэлтэд бас нөлөөлсөн.

Сургуульд суралцаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь бүх насны бүлэгт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаа нь эмэгтэйчүүд суралцагчдын дотор давамгайлж байгааг илтгэнэ. Эмэгтэйчүүдийн энэ давуутай байдал хот, хөдөөд аль алинд нь харагдлаа. Нас, боловсролын түвшин дээшлэх тутам эмэгтэйчүүдийн давамгай байдал өссөөр байгаа нь анхаарал татлаа. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол сургуульд ороходоо төдийгүй орсныхоо дараа ч сургуулиас завсардахгүй, тууштай суралцаж байгаатай холбоотой.

Сургуульд суралцагчдын хүйсийн харьцаа 20-24, 25-29 насанд 120-140 болж, 30-34 насанд 161.3 хувь болсон байна.

ЗУРАГ 6.4. СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, (100 ЭРЭГТЭЙД НОГДОХ ЭМЭГТЭЙН ТОО) НАСНЫ БҮЛГЭЭР, 2010 ОН



Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нас буюу 2-оос 5 насны хүүхдийн 56.5 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байна. Сургуульд орох нас дөхөх тусам сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт нэмэгджээ. Тухайлбал, 2 настай хүүхдийн 43.5 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан бол 5 настай хүүхдүүдийнх 71.6 хувь нь хамрагдлаа. Хотод амьдардаг хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 79.9 хувь байхад хөдөөд 52.7 хувь байгаа нь хөдөөгийн малчдад энэ чиглэлийн үйлчилгээ ихээхэн хэрэгцээтэй байгааг харуулна.

ХҮСНЭГТ 6.7. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, НАС, ХОТ, ХӨДӨӨГ, ХУВИАР, 2010 ОН

Нас	Бүгд		Байршил			
			Хот		Хөдөө	
	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь
БҮГД	**3756**	**56.5**	**744**	**79.9**	**3012**	**52.7**
2	880	43.5	190	65.7	690	39.8
3	947	53.7	190	79.5	757	49.7
4	930	63.6	187	91.2	743	59.1
5	999	71.6	177	89.4	822	68.7

ДҮГНЭЛТ

Боловсролын түвшин

Арав, түүнээс дээш насны хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс 4.8 пунктээр нэмэгдлээ. Арав, түүнээс дээш насны хүн амд дээд боловсролтой хүн амын эзлэх хувь өнгөрсөн 11 жилд 6.1 пунктээр нэмэгдсэн нь нэг талаар сайн үзүүлэлт боловч дээд, тусгай дунд, мэргэжлийн боловсролтой хүн амын зохистой харьцаа алдагджээ.

Боловсрол эзэмшигчдийг хүйсээр авч үзэхэд нэлээд ялгаатай байна. Ялангуяа, дээд боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь хоёр тооллогын хооронд 3.9 пунктээр өссөн байхад эмэгтэйчүүдийнх 8.7 пунктээр нэмэгдсэн дүн гарлаа.

Хот, хөдөөгийн хүн амын боловсролын түвшин ихээхэн ялгаатай бөгөөд боловсролын

түвшин дээшлэх тутамд зөрүү нь нэмэгджээ. Боловсролгүй хүний эзлэх хувь хөдөөд хотоос 3.6 пунктээр их байна. Хөдөөд дээд, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс илүү юм. Харин суурь болон бага боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаагаас үзэхэд хөдөөгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсролтой байна. Энэ байдал хотод ч бас ижил хандлагатай байна.

Бичиг үсгийн мэдлэг

Төв аймгийн хувьд 15, түүнээс дээш насны хүн амын 97.5 хувь бичиг үсэг мэдэж байгаа нь 2000 оноос 0.6 пунктээр нэмэгдсэн боловч улсын дунджаас 0.8 пунктээр доогуур гарлаа. Төв аймгийн хувьд 15-29 насны залуучуудын 2.4 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаа нь бага мэт боловч хүнийхээ тооноос хамаарч тэд нийт бичиг үсэг мэддэггүй 15, түүнээс дээш насны хүн амын 36.1 хувийг эзэлж байгаад онцгой анхаарах ёстой бөгөөд цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиглээр орон нутгийн бодлого шийдвэр гаргаж ажиллах шаардлагатай нь харагдлаа. Төв аймагт хотын бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувийг 2000 онтой харьцуулахад 0.7 пунктээр буурсан байна.

Сургууль, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт

Сургуульд хамрагдалт 11 жилийн өмнөхөөс сайжирч, 2000 онд 8 насны хүн амын 87.6 хувь нь сургуульд сурч байсан бол 2010 онд 98.1 хувь болж өсчээ. Есөн настай хүүхдийн сургуульд хамрагдалт 2000 онд 94.0 хувь байсан бол 2010 онд 98.6 хувь болж нэмэгдлээ. Сургуульд хамрагдалт 15 наснаас эхлэн буурч байгаагаас үзэхэд бүрэн дунд боловсрол эзэмших насны хүүхдийн сургуульд хамрагдалт эрс нэмэгдсэнийг гэрчилнэ.

Бүх насны бүлэгт сургуульд суралцаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс илүү байна. Эмэгтэйчүүдийн энэхүү давуу байдал хот, хөдөөд ч адил байгаа юм.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нас буюу 2-оос 5 насны хотын хүүхдүүдийн 79.9 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байгаа бол хөдөөгийн 52.7 хувь нь төрийн үйлчилгээ авчээ. Иймд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хөдөөгийн хоёр хүүхдийн нэг нь цэцэрлэгт хүмүүжиж байгаад дүгнэлт хийж цаашид анхаарах шаардлагатай.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

ӨРХИЙН ТОО, БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор өрхийг өмнөх тооллогын нэгэн адил судалсан боловч өрхөд тоологдсон, өрх үүсгээгүй тоологдсон хүний тодорхойлолт өмнөх тооллогоос ялгаатай байлаа. Гэр бүл, ураг төрлийн хамааралтай хүмүүс өрх үүсгэж тоологдох, хоорондоо огт хамааралгүй хүмүүс нэг орон байранд хамт тоологдох гэсэн 2 хэлбэр байлаа. Өрхөд хамаарахгүй хүмүүст цэрэг, хоригдол, оюутнууд, албан болон албан бусаар ашигт малтмал олборлогчид, орон гэргүй иргэд зонхилж байв.

ЗУРАГ 7.1. ӨРХ, ӨРХӨД ХАМААРАЛГҮЙ ТООЛОГДСОН ХҮН АМЫН ТОО, 2010 ОН

Хүн амын 96.2 хувь нь 24.7 мянган өрхөд, үлдсэн 3.8 хувь буюу 3174 хүн өрхөд хамаарахгүйгээр тоологджээ.

ХҮСНЭГТ 7.1. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Байршил	2000		2010		2010/2000 (%)
	Мян.өрх	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь	
БҮГД	**23.6**	**100**	**24.7**	**100**	**104.4**
Хот	3.8	16.0	3.8	15.4	100.3
Хөдөө	19.8	84.0	20.9	84.6	105.2

Нийт өрхийн тоо 2000 оныхоос 4.4 хувиар өссөний дотор хөдөөгийн өрх 5.2 хувиар өсчээ. Төв аймгийн хувьд хүн амын тоо буурсан боловч өрхийн тоо өссөн тохиолдол гарсан нь өрхүүд хуваагдаж, өрх үүсгэж амьдардаг болсонтой холбон үзэж болох юм.

Хүн ам, орон сууны 2000 оны тооллогоос эхлэн НҮБ-ын аргачлалын дагуу өрхийг хэлбэрээр нь ангилан тодорхойлж байна. Ингэж ангилахдаа өрхийн гишүүд өрхийн тэргүүлэгчтэйгээ ямар хамааралтай болохыг харгалзаж үздэг. Өрхийг хэлбэрээр ангилсан тодорхойлолтыг 1 дүгээр бүлгийн “Тооллогод хэрэглэсэн ойлголт, тодорхойлолт” гэсэн хэсгээс үзнэ үү.

ЗУРАГ 7.2. ӨРХИЙН ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН



Нийт өрхийн 14.0 хувь нь ганц бие, 68.4 хувь нь ам бүлээрээ байгаа, 16.0 хувь нь нийлмэл, 1.6 хувь нь холимог ам бүлтэй өрх байна. Нийт өрхийн дотор ам бүлээрээ буюу нөхөр, эхнэр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх дийлэнх хувийг эзэлжээ. Мөн нийлмэл буюу эцэг эх, ах, дүүс, садан төрлөөрөө хамт амьдарч байгаа өрх ч олон юм. Энэ нь өрхийн ам бүлийн бүтцийн түгээмэл хэлбэрүүд бөгөөд үр хүүхэд, хамаатан садантайгаа хамт амьдрах нь эцэг эх, ахмад настнаа хүндлэн асардаг манай уламжлалт заншилтай холбоотой.

ХҮСНЭГТ 7.2. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010 ОН

Байршил	Бүгд	Ганц бие өрх		Ам бүлээрээ байгаа өрх		Нийлмэл ам бүлтэй өрх		Холимог ам бүлтэй өрх	
	Өрх	Өрх	Хувь	Өрх	Хувь	Өрх	Хувь	Өрх	Хувь
БҮГД	**24687**	**3458**	**14.0**	**16890**	**68.4**	**3942**	**16.0**	**397**	**1.6**
Хот	3802	416	11.0	2457	64.6	902	23.7	27	0.7
Хөдөө	20885	3042	14.6	14433	69.1	3040	14.5	370	1.8

Өрхийн бүтцийг хот, хөдөөгөөр ангилахад ялгаатай байдал нэлээд ажиглагдана. Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хотод (902) хөдөөнөөс (3040) 3.4 дахин бага байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс (2000 онд энэ үзүүлэлт 4.1 дахин бага байсан) буурчээ. Үүний зэрэгцээгээр аймагт ганц бие өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 2 дахин өссөнийг шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болох юм.

ХҮСНЭГТ 7.3. ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2010 ОН

Байршил	Бүгд	Ам бүлийн тоогоор									
		1-2		3-4		5-6		7+			
	Өрх	Хувь	Өрх	Хувь	Өрх	Хувь	Өрх	Хувь	Өрх	Хувь	
БҮГД	**24687**	**100.0**	**8195**	**33.2**	**11494**	**46.5**	**4431**	**17.9**	**567**	**2.3**	
Хот	3802	100.0	1100	28.9	1946	51.2	647	17.0	109	2.9	
Хөдөө	20885	100.0	7095	33.9	9548	45.7	3784	18.2	458	2.2	

Аймгийн хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 2000 онд 4.1 байсан бол 2010 онд 3.3 болж буурав. Өрхийн ам бүлийн тоо хот, хөдөөд ялгаатай байгаа боловч 7-оос дээш ам бүлтэй өрхийн эзлэх хувь хот, хөдөөд бараг адил байна.

ХҮСНЭГТ 7.4. УЛС БОЛОН АЙМГИЙН АМ БҮЛИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Байршил	1-2		3-4		5-6		7+	
	Улсын дундаж	Аймгийн дундаж	Улсын дундаж	Аймгийн дундаж	Улсын дундаж	Аймгийн дундаж	Улсын дундаж	Аймгийн дундаж
БҮГД	**26.7**	**33.2**	**47.3**	**46.6**	**21.6**	**17.9**	**4.4**	**2.3**
Хот	25.9	28.9	47.9	51.2	21.3	17.0	4.9	2.9
Хөдөө	28.4	33.9	46.1	45.7	22.1	18.2	3.4	2.2

Аймгийн өрхийн ам бүлийн дундаж тоо улсын дунджаас 0.3 хүнээр цөөн тоологдлоо. Аймагт 1-2 ам бүлтэй өрхүүдийн эзлэх хувь хотод ч, хөдөөд ч улсын дунджаас илүү, харин 7-гоос дээш ам бүлтэй өрхүүдийнх бүх түвшинд цөөн гарлаа

Өрхийн ам бүлийн дундаж тоо Сүмбэр суманд хамгийн өндөр бөгөөд Батсүмбэр, Баянхангай, Борнуур, Бүрэн, Сүмбэр, Цээл, Зуунмод сумдад мөн аймгийн дунджаас олон байна.

ХҮСНЭГТ 7.5 ӨРХИЙН ТОО, СУМААР, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2010 ОН

Сумын нэр	Бүгд	Ам бүлийн тоогоор				Өрхийн ам бүлийн дундаж тоо
		1-2	3-4	5-6	7+	
БҮГД	**100.0**	**33.2**	**46.6**	**17.9**	**2.3**	**3.3**
Алтанбулаг	100.0	34.8	49.3	15.1	0.8	3.1
Аргалант	100.0	39.9	40.8	18.2	1.1	3.1
Архуст	100.0	34.7	40.9	20.7	3.7	3.3
Батсүмбэр	100.0	32.7	43.2	19.9	4.2	3.4
Баян	100.0	34.1	44.3	19.5	2.1	3.3
Баяндэлгэр	100.0	41.7	40.9	14.7	2.7	3.0
Баянжаргалан	100.0	26.9	54.7	17.6	0.8	3.3
Баян-Өнжүүл	100.0	27.5	53.0	19.1	0.5	3.3
Баянхангай	100.0	30.1	47.9	17.5	4.5	3.4
Баянцагаан	100.0	32.0	56.1	11.2	0.7	3.1
Баянцогт	100.0	39.1	41.0	16.9	3.0	3.2
Баянчандмань	100.0	36.4	44.2	17.0	2.4	3.2
Борнуур	100.0	30.3	45.8	20.9	3.0	3.5
Бүрэн	100.0	26.8	47.2	23.9	2.1	3.5
Дэлгэрхаан	100.0	34.6	44.2	18.0	3.2	3.3
Жаргалант	100.0	35.1	43.0	19.8	2.1	3.2
Заамар	100.0	31.1	51.8	15.7	1.4	3.2
Лүн	100.0	34.8	48.1	16.1	1.0	3.2
Мөнгөнморьт	100.0	38.7	44.7	15.6	1.0	3.0
Өндөрширээт	100.0	37.8	45.3	15.8	1.1	3.1
Сүмбэр	100.0	26.8	46.0	23.0	4.2	3.6
Сэргэлэн	100.0	38.3	45.1	14.1	2.5	3.1
Угтаал	100.0	34.1	46.3	18.0	1.6	3.2
Цээл	100.0	27.8	46.5	22.2	3.5	3.5
Эрдэнэ	100.0	44.3	38.8	15.9	1.1	2.9
Эрдэнэсант	100.0	31.5	46.5	20.1	1.8	3.3
Зуунмод	100.0	28.9	51.2	17.0	2.9	3.4

Долоо, түүнээс дээш ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Баянхангай, Сүмбэр, Батсүмбэр, Архуст, Цээл, Дэлгэрхаан, Борнуур, Баянцогт сумд, Зуунмод хотод энэ үзүүлэлт аймгийн дунджаас илүү байна.

ХҮСНЭГТ 7.6. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Өрх	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	**24687**	**100.0**	**3802**	**100.0**	**20885**	**100.0**
Эрэгтэй тэргүүлэгчтэй	20315	82.3	2881	75.8	17434	83.5
Эмэгтэй тэргүүлэгчтэй	4372	17.7	921	24.2	3451	16.5

Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхээс 4 пунктээр, байршлын хувьд хотод 7.1, хөдөөд 3.4 пунктээр нэмэгджээ. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо нэмэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн амын гэр бүл болох үндсэн чиг хандлага тооллого хоорондын жилүүдэд эрс өөрчлөгдөөгүй боловч нарийвчлан авч үзвэл ялгаа бий болсон нь ажиглагдана. Хамгийн мэдэгдэхүйц өөрчлөлт бол огт гэр бүл болоогүй хүмүүсийн эзлэх хувь 2000 онд 30.5 хувь байсан бол өмнөх үеийнхээс 2010 онд 4.1 пунктээр буурчээ. Энэ нь 2007-2008 онд төр засгаас залуу гэр бүлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд залуучууд гэр бүл болох нь нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

ХҮСНЭГТ 7.7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Гэр бүлийн байдал	2000		2010	
	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь
БҮГД	**63333**	**100.0**	**59667**	**100.0**
Огт гэр бүл болоогүй	19317	30.5	15761	26.4
Гэр бүлтэй[1]	38152	60.3	38435	64.4
Цуцалсан[2]	1728	2.7	1711	2.9
Бэлбэсэн	4136	6.5	3760	6.3

[1] батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

[2] тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Сүүлчийн 11 жилийн хугацаанд 15, түүнээс дээш насны хүн амд гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүн амын эзлэх хувь өсч, бэлбэсэн хүн амын эзлэх хувь буурсан байна. Үүнийг улсын дундажтай харьцуулахад Төв аймгийн гэр бүлтэй хүний эзлэх хувь улсын дунджаас 4.3 пункт, бэлбэсэн хүний эзлэх хувь 0.8 пунктээр их, харин гэр бүлээ цуцалсан хүний эзлэх хувь 0.2 пунктээр бага байна.

ХҮСНЭГТ 7.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН

Гэр бүлийн байдал	2000		2010	
	Улсын дундаж	Аймгийн дундаж	Улсын дундаж	Аймгийн дундаж
БҮГД	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**
Огт гэр бүл болоогүй	33.1	30.5	31.3	26.4
Гэр бүлтэй[1]	57.8	60.3	60.1	64.4
Цуцалсан[2]	2.7	2.7	3.1	2.9
Бэлбэсэн	6.4	6.5	5.5	6.3

[1] батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.
[2] тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Өмнөх тооллогын үед гэр бүлээ цуцалсан эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс олон байсан бол 2010 онд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс олон болжээ. Хүн амын дунд гэр бүл цуцлалт нэмэгдэж байгааг онцгой анхаарч, түүний шалтгаан нөхцөлийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

ХҮСНЭГТ 7.9. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Гэр бүлийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь	Хүн	Дүнд эзлэх хувь
БҮГД	**59667**	**100.0**	**31306**	**100.0**	**28361**	**100.0**
Огт гэр бүл болоогүй	15761	26.4	9936	31.7	5825	20.5
Гэр бүлтэй[1]	38435	64.4	19604	62.6	18831	66.4
Цуцалсан[2]	1711	2.9	900	2.9	811	2.9
Бэлбэсэн	3760	6.3	866	2.8	2894	10.2

[1] батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.
[2] тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа нөхөрт гардгийг харуулна. Тиймээс ч эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага байдаг. Огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхээс 4.5 пунктээр буурчээ.

Анхны гэрлэлтийн дундаж нас гэсэн үзүүлэлт нь эрэгтэй, эмэгтэйчүүд дунджаар анх хэдэн насандаа гэр бүл болж байгааг илэрхийлдэг.

ЗУРАГ 7.3. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, 1989, 2000, 2010 ОН



ХҮСНЭГТ 7.10. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС, 1989, 2000, 2010 ОН

Он	Төв аймаг		Улс		Аймаг, улсын зөрүү /+,-/	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
1989	24.9	22.3	23.3	21.1	1.6	1.2
2000	25.6	22.7	25.7	23.7	-0.1	-1.0
2010	26.4	22.9	26.2	24.2	0.2	-1.3

Нийгэм, эдийн засаг хөгжиж, залуу үеийнхний боловсролын түвшин дээшлэх тутам тэдний анхны гэрлэлтийн дундаж нас хойшилж байдаг зүй тогтолтой. Манай аймгийн хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас сүүлчийн 20 жилд эмэгтэйчүүдэд бараг өөрчлөлт гараагүй, харин эрэгтэйчүүдэд 1.5 насаар хойшилсон байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж насны ялгаа 3.5 нас байгаа нь сүүлийн 20 жилд 1 насаар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 7.11. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Насны бүлэг	Эрэгтэй					Эмэгтэй				
	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй°	Цуцал-сан[1]	Бэлбэсэн	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Гэр бүлтэй°	Цуцал-сан[1]	Бэлбэсэн
БҮГД	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**
15-24	25.8	69.2	6.0	2.8	0.0	22.2	74.9	10.0	4.7	0.2
25-34	24.3	20.3	27.4	21.3	2.3	23.6	14.1	29.7	26.0	2.2
35-44	20.5	6.6	27.5	36.0	6.2	21.1	5.9	27.2	32.6	8.8
45-54	15.9	2.4	22.1	27.4	17.1	17.4	3.5	20.8	25.5	21.3
55-64	7.6	0.9	10.4	7.6	22.1	8.2	0.9	8.2	6.5	23.3
65+	5.9	0.6	6.6	4.9	52.3	7.5	0.7	4.1	4.7	44.2
БҮГД	**100.0**	**31.7**	**62.6**	**2.9**	**2.8**	**100.0**	**20.5**	**66.4**	**2.9**	**10.2**
15-24	100.0	85.2	14.5	0.3	0.0	100.0	69.3	30.0	0.6	0.1
25-34	100.0	26.5	70.7	2.5	0.3	100.0	12.3	83.6	3.2	0.9
35-44	100.0	10.2	84.0	5.0	0.8	100.0	5.7	85.6	4.4	4.3
45-54	100.0	4.9	87.2	4.9	3.0	100.0	4.1	79.2	4.2	12.5
55-54	100.0	3.6	85.5	2.9	8.0	100.0	2.3	66.5	2.3	28.9
65+	100.0	3.3	69.8	2.4	24.5	100.0	2.0	36.2	1.8	60.0

[1] *батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.*
[2] *тусгаарласан хүмүүсийг оруулсан.*

Нөгөө талаар 15-34 насанд нөхөрт гарсан эмэгтэйчүүд, 35-аас дээш насанд гэрлэсэн эрэгтэйчүүд олон байхад аль ч насанд бэлбэсэн эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс мэдэгдэхүйц их байна (хүснэгт 7.9). Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү урт насалдагтай

холбоотойгоор тэд эрэгтэйчүүдээс эрт бэлбэсэрч байгааг илтгэнэ. Ялангуяа, 65, түүнээс дээш насанд бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 827 хүнээр илүү байна. Мөн эмэгтэйчүүд хэдийгээр бэлбэсэрсэн ч дахин нөхөрт гарах магадлал эрэгтэйчүүдийнхээс бага байдгийг харуулжээ. Энэ зүй тогтол 2000 оны тооллогын үр дүнгээс ч тодорхой харагддаг юм.

ЗУРАГ 7.4. ГЭР БҮЛЭЭ ЦУЦАЛСАН ХҮН АМЫН ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН



ДҮГНЭЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор нийт өрхийн тоо 2000 оныхоос 4.4 хувиар, харин хөдөөгийн өрх 5.2 хувиар өссөн байгаа нь хөдөөд өөр аймгаас хүмүүс шилжин ирсэнтэй холбоотой.

Нийлмэл ам бүлтэй өрхийн тоо хөдөөд хотоос 3.4 дахин олон байна. Энэ нь хөдөө сумандаа орон сууцны хүрэлцээ хангамж тааруу байгааг харуулж байна.

Аймгийн хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 2000 онд 4.1 байсан бол 2010 онд 3.3 болж буурав. 2010 онд 2000 оныхоос 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгджээ. Тухайлбал, 2000 оны тооллогоор 1-2 ам бүлтэй өрх хөдөөд хотоос 2.6 пунктээр илүү байсан бол 2010 онд харин 5 пунктээр илүү боллоо. Энэ нь төв газарт их, дээд сургуульд суралцагчид болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирэгчид тусдаа өрх болж тоологдсонтой холбоотой.

Хүн амын гэр бүлийн байдалд гарсан хамгийн мэдэгдэхүйц өөрчлөлт бол огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 1989-2000 оны тооллого хооронд нэмэгдэж байсан бол сүүлчийн 11 жилд 4.1 пунктээр буурав. Энэ нь 2007-2008 онуудад төр, засгаас залуу гэр бүлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд залуучууд гэрлэх нь нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

Анхны гэрлэлтийн дундаж нас эмэгтэйчүүдэд бараг өөрчлөгдөөгүй, харин эрэгтэйчүүдэд 1.5 насаар хойшилжээ. 2000-2010 оны хооронд нэг насаар хойшилжээ. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа 3.5 насны зөрүүтэй байгаа нь сүүлчийн 20 жилд 1 насаар нэмэгджээ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, БҮТЭЦ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үзсэн[1].

Төв аймгийн хэмжээнд 2010 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 3825 хүн байгаа нь хүн амын 4.6 хувийг эзлэв. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 2205 буюу 57.6 хувь нь эрэгтэй, 1620 буюу 42.4 хувь нь эмэгтэйчүүд юм.

ХҮСНЭГТ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
БҮГД	**3825**	**100.0**	**2205**	**100.0**	**1620**	**100.0**
0-4	72	1.9	38	1.7	34	2.1
5-9	107	2.8	64	2.9	43	2.7
10-14	137	3.6	80	3.6	57	3.5
14-19	207	5.4	133	6.0	74	4.6
20-24	272	7.1	172	7.8	100	6.2
25-29	332	8.7	188	8.5	144	8.9
30-34	344	9.0	186	8.4	158	9.7
35-39	383	10.0	216	9.8	167	10.3
40-44	385	10.1	212	9.6	173	10.7
45-49	454	11.9	239	10.9	215	13.3
50-54	408	10.7	257	11.7	151	9.3
55-59	238	6.2	151	6.9	87	5.4
60-64	140	3.6	86	3.9	54	3.3
65-69	108	2.8	62	2.8	46	2.8
70+	238	6.2	121	5.5	117	7.2

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 9.0 хувь нь 10-19 нас буюу өсвөр үеийнхэн, 15.8 хувь нь 20-29 насныхан, 19.0 хувь нь 30-39 насныхан, 22.0 хувь нь 40-49 насныхан, 16.9 хувь нь 50-59 насныхан үлдсэн нь 60-аас дээш насныхан байгаа бөгөөд 35-54 насныхан 1630 буюу хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 42.7 хувийг эзлэв

[1] Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл II боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 280

ЗУРАГ 8.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүний дийлэнх хувийг 40-54 насныхан эзэлж байгааг дээрх суваргаас харж (Зураг 8.1) болно. Тэдний дийлэнх нь үйлдвэрлэлийн болон ахуйн ослоос хамаарч хөгжлийн олдмол бэрхшээлтэй болсон байх талтай.

ХҮСНЭГТ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, СУМ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Сумын нэр	Бүгд		Хүйс		Нийт хүн амд эзлэх хувь
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	**3825**	**100.0**	**2205**	**1620**	**4.6**
Алтанбулаг	75	2.0	47	28	3.1
Аргалант	50	1.3	31	19	3.6
Архуст	55	1.4	32	23	4.5
Батсүмбэр	443	11.6	257	186	6.4
Баян	89	2.3	39	50	4.5
Баяндэлгэр	65	1.7	42	23	4.4
Баянжаргалан	65	1.7	44	21	4.7
Баян-Өнжүүл	50	1.3	29	21	3.3
Баянхангай	61	1.6	36	25	4.9
Баянцагаан	45	1.2	26	19	3.2
Баянцогт	117	3.1	77	40	6.7
Баянчандмань	160	4.2	91	69	4.3
Борнуур	195	5.1	95	100	4.5
Бүрэн	113	2.9	60	53	4.1
Дэлгэрхаан	65	1.7	40	25	4.7
Жаргалант	270	7.1	172	98	4.8
Заамар	167	4.4	89	78	2.5
Лүн	139	3.6	86	53	5.7
Мөнгөнморьт	199	5.2	109	90	9.2
Өндөрширээт	83	2.2	38	45	4.9
Сүмбэр	56	1.5	33	23	3.2
Сэргэлэн	113	2.9	64	49	4.3
Угтаал	98	2.6	55	43	4.2
Цээл	99	2.6	65	34	3.9
Эрдэнэ	193	5.0	106	87	5.1
Эрдэнэсант	154	4.0	102	52	3.8
Зуунмод	606	15.8	340	266	4.5

Мөнгөнморьт, Баянцогт, Батсүмбэр, Баянжаргалан, Дэлгэрхаан, Жаргалант, Баянхангай, Өндөрширээт, Эрдэнэ, Лүн, сумын хүн амын дотор хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх хувь аймгийн дунджаас 4.7-9.3 пунктээр их, Заамар, Сүмбэр, Эрдэнэсант, Цээл, Бүрэн, Баянчандмань, Сэргэлэн, Угтаал, Борнуур, Архуст, Баян, Зуунмод сумдад 0.02-2.0 пунктээр бага байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 606 буюу 15.8 хувь нь Зуунмод суманд буюу хотод, 3219 буюу 84.2 хувь нь бусад сумын төв, хөдөөд амьдарч байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор 3825 хөгжлийн бэрхшээлтэй хүн тоологдсоны 1425 буюу 37.3 хувь нь төрөлхийн, үлдсэн 2400 буюу 62.7 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юм.

ЗУРАГ 8.2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 54.7 хувь, олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 59.4 хувь эрэгтэйчүүд байгаа нь (хүснэгт 8.4) тэд эмэгтэйчүүдтэй харьцуулахад үйлдвэрлэлийн болон ахуйн осол, хоол хүнсний зохисгүй хэрэглээ, амьдралын буруу зуршил зэргээс хамаарч хөгжлийн бэрхшээлтэй болдогтой холбоотой. Улсын дунджаас хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн хувьд төрөлхийнх 4.1 пунктээр, олдмолынх 1.8 пунктээр их байна.

ХҮСНЭГТ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХҮЙС, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ХУВИАР, 2010 ОН

Төрөл	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрөл			
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Төрөлхийн	Дүнд эзлэх хувь	Олдмол	Дүнд эзлэх хувь
БҮГД	**3825**	**100.0**	**1425**	**100.0**	**2400**	**100.0**
Хүйс						
Эрэгтэй	2205	57.6	780	54.7	1425	59.4
Эмэгтэй	1620	42.4	645	45.3	975	40.6
Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр						
Харааны	641	16.7	198	13.9	443	18.4
Ярианы	204	5.3	142	10.0	62	2.6
Сонсголын	526	13.8	169	11.9	357	14.9
Хөдөлгөөний	1012	26.5	274	19.2	738	30.8
Сэтгэцийн	934	24.4	552	38.7	382	15.9
Бусад*	508	13.3	90	6.3	418	17.4

** хавсарсан болон бусад хэлбэрийн бэрхшээлийг энд оруулав.*

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс 38.7 хувь байгаа нь хамгийн өндөр, харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 30.8 хувийг эзэлж байгаа нь хамгийн их байна. Ялангуяа, төрөлхийн болоод сэтгэцийн бэрхшээлтэй хүн амын хувь их байгааг удамшлын эмгэг, эх барихын болон төрөх үеийн хүндрэл зэрэг шалтгаанаар олон талаас нь нарийвчилж судлах шаардлагатай. Дараагийн анхаарал татаж байгаа асуудал нь төрөлхийн болоод ярианы бэрхшээлтэй хүн амын хувь олдмол бэрхшээлтэй хүнийхээс 3.8 дахин их байгаа явдал юм. Хөгжлийн бэрхшээлийн төрлийг хэлбэрээр нь ангилж үзвэл ярианы болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн талаас илүү хувь нь төрөлхийн, бусад хэлбэрүүдийн хувьд олдмол бэрхшээл нь давамгайлжээ.

ЗУРАГ 8.3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ТӨРӨЛ, ХЭЛБЭРЭЭР, ХУВИАР, 2010 ОН



ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд 3825 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь хүн амын 4.6 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 2205 буюу 57.6 хувь нь эрэгтэй, 1620 буюу 42.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс 38.7 хувь байгаа нь хамгийн өндөр юм. Тиймээс үүнийг удамшлын эмгэг, эх барихын болон төрөх үеийн хүндрэл зэрэг шалтгаанаар олон талаас нь нарийвчилж судлах хэрэгтэй.

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд хөдөлгөөнийнх 30.8 хувь, харааных 18.4 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байгааг холбогдох байгууллагууд нарийвчлан судалж, цаашид шалтгаан нөхцлийн олж тодруулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж буруулах зорилт тавихыг чухал гэж үзэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс орны хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлэх, тэдний онцлог, хэрэгцээ шаардлагыг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлстэй хамааруулж судлах, улмаар ахуй нөхцөл, амьжиргааг нь дээшлүүлэхэд ашиглагдах мэдээллийн бодитой эх үүсвэр бий болгох шаардлагатай.

ЕСЛУГЭЭР БҮЛЭГ

ГАР УТАС, ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

Үүрэн технологид суурилсан, нийтийн телефон сүлжээнд (үүрэн холбооны оператор) холбогдсон авсаархан, зөөврийн телефон хэрэглэгчийг үүрэн утас хэрэглэгч гэж үзсэн. Хамгийн гол нь үүрэн утаснаас гадна тусгай дугаарын хамт хэрэглэж байгаа тохиолдлыг хэрэглэгч гэсэн ойлголтод хамааруулсан юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор манай аймгийн 6, түүнээс дээш насны хүн амын 68.9 хувь буюу 50.3 мянган иргэн гар утас хэрэглэж байна. Тэдний 50.1 хувь нь эрэгтэй, 49.9 хувь нь эмэгтэйчүүд ажээ.

ЗУРАГ 9.1. ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



Хөдөлмөрийн нас болох 15-59 насны хүн амын 85.3 хувь нь гар утас хэрэглэж байгаагаас 20-24 насныхан хамгийн их хэрэглэгчид байна.

ЗУРАГ 9.2. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СУМААР 2010 ОН



Гар утас хэрэглэгчийн 79 хувь нь хот, суурин газар, үлдсэн хувь нь хөдөө амьдарч байгаа бөгөөд үүрэн холбооны техник, технологи төв суурин газар өргөн нэвтэрсэн нь харагдана. Манай аймгийн Зуунмод, Заамар, Жаргалант, Аргалант, Баянчандмань, Цээл, Лүн сумдын хүн амын гар утасны хэрэглээ аймгийн дунджаас өндөр, Зуунмод, Заамар, Жаргалант сумдын хүн амын гар утасны хэрэглээ улсын дунджаас 1.0-5.0 пунктээр илүү байна.

ЗУРАГ 9.3. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СУМААР 2010 ОН



ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО, БҮТЭЦ

Телефон утас болон түрээсийн шугам, өндөр хурдны хэрэглэгчийн тоон шугам буюу DSL, ADSL, байнгын гарцтай, өндөр хурдны кабель модем, шилэн кабель хэрэглэгчдийг интернет хэрэглэгч гэж үзсэн. Интернетийн байнгын хэрэглээг гэртээ болон гэрээсээ бусад газар 7 хоногийн ихэнх хугацаанд хэрэглэж байгаа тохиолдлоор, тухайн үеийн хэрэглээг интернет үйлчилгээний цэг зэрэг газарт шаардлага гарсан үедээ хэрэглэж байвал шаардлагатай үед гэж тодорхойлсон.

Тооллогын дүнгээр 6, түүнээс дээш насны хүн амын 16.4 хувь буюу 11979 хүн интернет хэрэглэж байна. Тэдний 10.1 хувь нь гэртээ, 17.9 хувь нь албан газар зэрэг гэрээсээ өөр газар байнга хэрэглэж байхад 72.0 хувь нь шаардлагатай үедээ интернет хэрэглэдэг ажээ. Энэ байдлаас үзэхэд интернет хэрэглэдэг хүмүүсийн ихэнхи нь шаардлагатай үедээ интернет кафе буюу найз нөхөд, бусад хүмүүсийн интернетэд холбогдсон шугам ашиглажээ .

ЗУРАГ 9.4. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭЭ, 2010 ОН

Интернет хэрэглэгчийн 45.2 хувь нь эрэгтэйчүүд бол эмэгтэйчүүд 54.8 хувьтай байна. Интернет хэрэглэх нь хувь хүнээс тодорхой түвшний хэлний мэдлэг, компьютер, шаардлагатай мэдээллээ богино хугацаанд хайж олох чадвар шаарддаг. Тиймээс эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад илүү байгаатай холбоотойгоор эмэгтэйчүүд түлхүү хэрэглэдэг байж болох юм. Ялангуяа, энэхүү ялгааг хүний суралцах хамгийн идэвхтэй нас буюу 15-29 насанд тодорхой харж болно.

ЗУРАГ 9.5. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН.



Нийт интернет хэрэглэгчийн 34.8 хувь нь хотод, үлдсэн 65.1 хувь нь хөдөөд амьдарч байна.

ЗУРАГ 9.6. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СУМААР 2010 ОН



ЗУРАГ 9.7. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СУМААР 2010 ОН



ДҮГНЭЛТ

Монгол Улсын 6, түүнээс дээш насны суурин хүн амын 68.9 хувь буюу 50364 хүн гар утас хэрэглэж байна. Гар утас хэрэглэгч 18.5 хувь нь хот суурин амьдардаг ажээ. Гар утас хэрэглэгчийн дотор 15-29 насныхан хамгийн олон байна. Манай улсад гар утас, интернэтийн хэрэглээний үйлчилгээ нэвтрэн орсноор 15 жилийн хугацаа өнгөрчээ. Манай аймгийн хувьд мөн адил байна. Гар утас хэрэглэдэггүй 6, түүнээс дээш насны 31.1 хувь буюу 22691 хүн, интернэт хэрэглэдэггүй 83.6 хувь буюу 61076 хүн байна. Гар утсыг насны бүтцээр аваад үзэхэд 15-60 насныхан түлхүү хэрэглэж байхад интернэтийг залуучууд илүү хэрэглэжээ. Манай аймгийн хувьд Улаанбаатар хоттой ойр учраас 27 суманд гар утасны үүрэн телефон нэвтэрсэн.

Интернетийн хувьд Баян-Өнжүүл, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан, Мөнгөнморьт сумдаас бусад сумдад интернэт сүлжээ орлоо. Интернет хэрэглэгчийн 54.8 хувь нь эмэгтэйчүүд, 45.2 хувийг эрэгтэйчүүд эзлэв. Зургаа, түүнээс дээш насны хүн амын 16.4 хувь буюу 11979 хүн интернет хэрэглэж байгаагийн 28.0 хувь нь байнга, үлдсэн 76.0 хувь нь шаардлагатай үедээ хэрэглэдэг ажээ.

Интернетийг шаардлагатай үед илүү түлхүү хэрэглэжээ. Манай аймгийн хувьд аймгийн төвөөс бусад сумдад гэртээ интернет хэрэглэдэг өрх маш бага гарлаа.